“СҮХБААТАР” НЭГДСЭН ЭМНЭЛЭГ
# АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 06 сар

Улаанбаатар хот

ЗОРИЛГО: Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

ЗОРИЛТ:
- Шударга, хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгэг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх
- Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх
- Авлигаас сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих
- Авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх

| № | Үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд: Шударга, хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: | | | | |
| 1 | Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн | төрийн албаны төв зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, ХАСУМ-ийг холбогдох байгууллагаар хянуулсны дараа албан тушаалд томилох | Төрийн жинхэнэ албан тушаалд томилох үйл ажиллагаа хуулийн хүрээнд зохион байгуулах | ❖ Нээлттэй ажлын байрыг нийт ажилчидадаа болон байгууллагын гадна нээлттэй зарладаг. Шуурхай зар сонин, unegui.mn, СБНЭ-ийн пэйж хаяг, Нээлттэй ажлын байр пэйж хаяг, ажлын зар групп, цагийн ажлын зар групп, Монголын эрүүл мэндийн салбарынхны нэгдсэн групп, 1950, 1927, 1910, 1616, 1617 гэх мэт хөдөлмөр зуучлалын албанд зар өгч ажилтан шалгаруулж авдаг.<br>❖ Цахим хаяг: info@sbne.ub.gov.mn<br>❖ Нэгдсэн эмнэлэг нь ажилчдыг сонгон шалгаруулах журмын дагуу шинэ ажилчдыг шалгаруулан авдаг. Ажил горилогчдыг анкет бөглүүлж, бүрдүүлэх материалын жагсаалтыг өгч тухайн албан тушаалд сул орон тоо гарсан үед ярилцлагад ордог ба шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шалгалт өгдөг. Ажилтныг туршилтын хугацаа 3 сараар ажилд авна. 2025 онд нийт 56 хүн шинээр ажилд орсон байна. Хөдөлмөрийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | | | гэрээг цуцалсан – 56, тэтгэвэрт 2, жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан -12, нийт ажлаас чөлөөлөгдсөн – 70 хүн байна. Ажилд орох хүсэлт гаргасан мэргэжилтний бүртгэлийн сан байгуулж, шаардлагатай үед дуудаж, журмын дагуу сонгон шалгаруулалтаар ажилд авдаг. Эрүүл мэндийн салбарт нөөц багатай эмнэлгийн мэргэжилтнийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж сонгон шалгаруулдаг. |
| 2 | Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтнуудыг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмын баримтлан томилох, дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага ур чадварын шаардлагыг үндэслэн төрийн албанд томилох дэвшүүлэх | Ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур, ур чадварыг үндэслэн, төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдүүлэх | • Албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилж, албан тушаалтнуудыг мэдлэг, боловсролд суурилсан томилох, дэвшүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур, ур чадварыг үндэслэн, албан тушаалд томилох, дэвшүүлэх тогтолцоо бүрдүүлэн ажиллаж байна.<br>• Нэгдсэн эмнэлгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг тодорхой зааж ил байрлуулан, хөдөлмөрийн гэрээнд ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах асуудлыг тусган ажилласнаар ажил үүргийн хуваарь тодорхой болж, үйл ажиллагаа нийтэд ил ойлгомжтой чирэгдэлгүй болсон ба хувь хүний авлигад өртөх эрсдэлийг арилгаж байна. |
| 3 | Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд_ төрийн албан хаагчдын үр дүнг | Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл үнэлгээний журам батлагдан, | ❖ Ажил дүгнэх комисс жилд 2 удаа хуралдаж ажиллагчдын ажлын үр дүнг дүгнэдэг. Ажил дүгнэх хуралд тасгууд, чанарын алба, сувилахуйн алба, үйлчилгээний менежерүүдийн тус бүрийн өгсөн үнэлгээг үнэлэн тухайн ажилтны ажлын алдаа дутагдал, оноотой талыг ярилцаж, тухайн ажилтанд тохирох үнэлгээ өгдөг. Эмч, ажилчдын ажлыг Чанарын алба, Сувилахуйн алба, Үйлчилгээний баг, Тасгаас хамтран тусгай |

<table>
<tr>
<td></td>
<td>тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох, эрх зүйн зохицуулалтыг бий болгох</td>
<td>“Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт” KPI – ээр үнэлж, хүний нөөцийн бүртгэл хяналт, удирдлагын нэгдсэн санг бий болгох</td>
<td>үнэлгээний системийн өргөтгөлийг хийх</td>
<td>шалгуурын дагуу үнэлэн, 5 шатлалаар дүгнэж, Нэгдсэн Эмнэлгийн даргын тушаалаар урамшуулалт цалин олгон ажилладаг.<br>❖ МУ-ын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын дагуу цалин хөлс, урамшууллын механизмыг мөрдөн Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх, ажлын үр дүнг сайжруулах үүднээс ажил дүгнэсэн протокол, даргын тушаалын дагуу “А”, “В” үнэлгээний мөнгө ажилчдын цалин дээр сар бүр олгон ажиллаж байна. “А“ үнэлгээтэй 62 ажилчинд үндсэн цалингийн 13%-ийн нэмэгдэл, “В үнэлгээтэй 57 ажилчинд үндсэн цалингийн 8%-ийн нэмэгдлийг сар бүр бодон олгосон. 2025 оны байдлаар нийт 119 хүнд, “А” үнэлгээнд 127’171’720₮ /62 хүн/, “В” үнэлгээнд 60’795’106₮-ийн /57 хүнд/ харгалзах мөнгөний 100%-н олголт хийсэн байна.<br>❖ Эмч, сувилагч - эмнэлгийн тусгай мэргэжилтэн, асрагч, захиргааны туслах ажилчид гэсэн ангиллаар ажил дүгнэх чанарын шалгуур үзүүлэлт гаргасан ба Дотоод журамд энэхүү шалгуураар жилд 2 удаа ажлын үзүүлэлтээ дүгнүүлэх заалт оруулан баталгаажуулсан. Энэ нь эмч, эмнэлгийн ажилчдад ямар шалгуураар ажлаа дүгнүүлэх нь ил тод, шударга байх нөхцөл бүрдэж байна.</td>
</tr>
<tr>
<td>4</td>
<td>Нийтийн албан тушаалтанд холбогдох авилга, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дтоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх</td>
<td>Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч хянан шийдвэрлэх, мэдээллийн нэгдсэн санг үүсгэх</td>
<td>Өргөдөл гомдлыг хянах ёс зүйн хорооны үйл ажиллагаа сайжирч, ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтнуудын зөрчлийн мэдээллийн нээлттэй болгох</td>
<td>❖ Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 1-3 хоногийн хугацаанд шийдэж, дунджийг 1 оронтой тоонд оруулахаар төлөвлөсний дагуу 2025 оны 12 сарын 01-ны байдлаар байгууллагын хэмжээнд 41 хүсэлт ирсэнийг хугацаанд нь буюу 1-3 хоногт шийдвэрлэн хүсэлт гаргагч иргэнд мэдэгдлээ. 11-11 төвөөс ирсэн 30, байгууллагад бүртгэсэн 11 хүсэлт, санал, гомдолыг хүлээн авч эмч нарын яриа болон ажилчдын хурал дээр танилцуулсан. Нийт талархал 23, гомдол 12, санал 6 ирснийг хүлээн авч гомдлын дагуу чанарын алба хэлэлцэн асуудлыг шийдвэрлэж гомдол гаргасан иргэдэд хариу мэдэгдэж, талархалыг ажилчдын хурал дээр танилцуулан, саналыг удирдлагын багаар хэлэлцэн 100 хувь шийдвэрлэлээ. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 1 хоног 09 цаг 57 минут байна. Индекс нь 94,00 хувьтай байна.<br><br>❖ Өргөдөл, гомдлын хандалтын тайлан
<table>
<tr><th>Д/д</th><th>Ангилал</th><th>Өргөдөл, гомдлын тоо</th><th>Өргөдөл гомдлын хувь</th></tr>
<tr><td>1</td><td>Хоёр дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний тухай</td><td>23</td><td>56.10 %</td></tr>
<tr><td>3</td><td>Яаралтай тусламж үйлчилгээний тухай</td><td>5</td><td>12.20%</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><td>3</td><td>Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны тухай</td><td>5</td><td>12.20%</td></tr>
<tr><td>4</td><td>Эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчийн ёс зүйн тухай</td><td>1</td><td>2.44%</td></tr>
<tr><td>5</td><td>Ажлаас чөлөөлөгдөх тухай</td><td>4</td><td>9.76%</td></tr>
<tr><td>6</td><td>Ажилд орох тухай</td><td>1</td><td>2.44%</td></tr>
<tr><td>7</td><td>Барилга байгууламжийн тухай</td><td>1</td><td>2.44%</td></tr>
<tr><td>8</td><td>Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай</td><td>1</td><td>2.44%</td></tr>
<tr><td colspan="2">Нийт өргөдөл, гомдлын дүн</td><td>41</td><td>100.00%</td></tr>
</table>
<ul>
<li>Авлига, хүнд суртал гарах эрсдэлээс сэргийлэн тандалт мэдээлэл цуглуулан, асуумж судалгаа авч ажиллаж байна. Тасаг нэгж бүрд “Талархлын эзэн” самбар байрлуулан санал хүсэлтийг авч Байгууллагын талархалын самбарт нийт тасаг бүрээс шалгарсан нэр бүхий 18 хүний зургийг нь тавьж алдаршуулж ажиллаж байна. Мөн “Талархал цуглуулцгаая!” идэвхжүүлэлтийн ажлыг зохион байгуулснаар тасаг бүрд “Сэтгэлийн илгээмж” буланг давхар бүрт нээн ажиллуулж “Талархлын хайрцаг”, Санал хүсэлтийн дэвтрийг үйлчлүүлэгчдийн өрөөгөөр аялуулж нийт эмнэлгийн хэмжээнд 1252 талархал, санал хүсэлт 34, гомдол 5 ирсэн бөгөөд ирсэн талархал, санал хүсэлтийг холбогдох алба нэгжид дамжуулан шийдвэрлүүлсэн болно.</li>
<li>Авлигын илрэл, хүнд суртал, ашиг сонирхлын зөрчлийг илрүүлэх, зорилгоор нэргүй хуудсаар асуумж авч түүнд дүгнэлт өгч, авлигын сэдэлтэй аливаа оролдлогыг мэдээлэхийг зөвлөсөн байгууллагын онцлогт тохирсон, сурталчилгааны хуудас, гарын авлага үйлчлүүлэгчдэд тарааж сурталчлан ажиллаж байна.</li>
</ul>
</td>
</tr>
<tr>
<td>5</td>
<td>Нийтийн албан сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх</td>
<td>Төрийн албан хаагчдад зориулсан богино хугацааны болон давтан сургалтуудыг зохион байгуулах</td>
<td>Төрийн албаны хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж хөтөлбөрийг боловсруулах</td>
<td>Жил бүрийн 1 улиралд ажилчдын сургалтын хэрэгцээний судалгаа авч, сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Ажилчдын зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг чадвар, хандлагыг тодорхойлон ажилласан.<br><br>2025 оны төгсөлтийн дараах сургалтанд хамрагдаж буй ажилчид
<table>
<tr><th>№</th><th>Нэрс</th><th>ПКТ</th><th>ХТ</th><th>ЗЭЯТТ</th><th>ДМТ</th><th>МЭГТ</th><th>ЗУТ+ААТ</th><th>Нийт</th></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| 5 | 4 | 3 | 2 | 1 |
|---|---|---|---|---|
| Эмчээр суралцдаг /сув/ | Магистр /сув/ | Магистр /эмч/ | Үндсэн мэргэшлийн сургалт | Төрөлжсөн мэргэжлийн сургалт |
| | | Д.Мөнхзул /АШУҮИС/ | Т.Сэлэнгэдэлгэр /бактериологи/ С.Ариунболд /ЯТ/ Д.Баярцэцэг/нүд/ У.Энхбямба /ЭХО/ Эмэгтэйчүүд – 2 эмч | 2024 онд төгссөн: Амартайван Лхагвадулам |
| М.Оюун-Эрдэнэ /АШУҮИС эмч/ Д.Мөнхжаргал – 2024 төгссөн | Г.Соёл-Эрдэнэ /Глобал/ А.Гантуяа /Глобал/ | Б. Соёл-Үндрах /АШУҮИС/ | Одонбаяр /хүүхэд/ Ц.Минсэл /хүүхэд/ Б.Үндрал /хүүхэд/ Х.Тэгшзаяа /хүүхэд/ | |
| Д.Ганбаатар /Этүгэн/ 2024 төгссөн: Т.Орчлон | А.Энхжаргал /АШУҮИС/ | Б.Энхтуяа /АШУҮИС/ | Т.Орчлон /ЯТ/ Н.Гомбосүрэн 2024 онд төгссөн: Г.Нарангоо /Эрчимт эмчилгээ/ Г.Номинзаяа /Эрчимт эмчилгээ/ | |
| | | Ж.Удвалцэцэг /АШУҮИС/ | Б.Мөнтуяа /дотор/ 2024 онд төгссөн: Б.Галхүү /дотор/ | 2024 онд төгссөн: Ж.Удвалцэцэг /дотоод шүүрэл/ А.Отгонзаяа /хоол боловсруулах/ С.Мандуухай /зүрх/ Т.Мөнцэцэг /зүрх/ |
| Д.Ням-Очир /Этүгэн/ | Ц.Баярмөнх /Глобал/ | | 2024 онд төгссөн: А.Буянжаргал /мэдээгүйжүүлэх/ Э.Хорлоо /мэдээгүйжүүлэх/ | Б.Энэрэл Д.Отгонсүрэн 2024 төгссөн: Б.Терсайхан // |
| | Д.Даваадням /АШУҮИС/ 2024 онд төгссөн: Ю.Уранчимэг | | | Э.Отгонбумба /ЭМТҮЧ/ 2025 төгссөн: Н.Сүх -Эрдэнэ /диализ/ |
| 3 | 5 | 4 | 13 | 3 |

| 11 | 10 | 9 | 8 | 7 | 6 |
|---|---|---|---|---|---|
| Асрагч | Туслах сувилагч | Сувилагч /диплом/ | Сувилагч /бакалавр/ | Үндсэн мэргэшлийн сургалт | Төрөлжсөн мэргэжлийн сургалт |
| | | | | | Б.Шинэбаяр /АШУҮИС ариутгагч/ М.Нацагмаа / АШУҮИС - био анагаахын мэргэжилтэн/ 2024 онд төгссөн: Д.Нарангэрэл /АШУҮИС -сэргээн засах/ |
| | | С.Мөнгөнтуул /Глобал/ | Б.Оюун-Эрдэнэ /УБИС/ Д.Ундармаа /Глобал/ Н.Нарантуяа /Энэрэл/ | | Г.Соёл-Эрдэнэ /нярай/ А.Гантуяа /нярай/ М.Нинжбадгар /нярай/ |
| | 2024 онд төгссөн: Э.Эрдэнэтуяа | | М.Анар /АШУҮИС/ П.Энхцэцэг /Глобал/ Б.Бат-Эрдэнэ /Глобал/ Г.Ундармаа /Глобал/ Э.Норовбанзад /Сити/ Б.Наранцацрал /Сити/ Н.Болор-Эрдэнэ /Глобал/ | | Е.Армангул Г.Ганчимэг /ариутгал/ 2024 хавар төгссөн: П.Тунгалаг Ц.Бямбасүрэн Л.Алтанзул |
| | | | 2024 онд төгссөн: Н.Дэлгэрцэцэг – Б.Энхчимэг – Д.Түвшинжаргал – | | |
| | | | Н.Дэлгэрцэцэг /АШУҮИС/ 2024 онд төгссөн: Д.Оюунсүрэн – | | 2024 төгссөн: Н.Дэлгэрцэцэг |
| | Т.Энхжаргал /Тегри/ | | | | |
| | 1 | 1 | 11 | | 7 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td>
<table>
<tr><td>12</td><td>Бусад</td><td></td><td>Б.Алтанцэцэг /Герман хэл/</td><td>Х.Ариунболор /Энэрэл -Эм зүй/<br>Г.Дуурэймаа /Энэрэл -Эм зүй/</td><td>Т.Гүнжинлхам /Энэрэл -Эм зүй/</td><td></td><td></td><td>4</td></tr>
<tr><td colspan="2">Нийт</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>52</td></tr>
</table>
2025 онд багц цагийн биелэлтийг хагас болон бүтэн жилээр тооцон ажиллаж байна. Ажилчдын багц цагийг бүрдүүлэхийн тулд ажилчдыг системтэйгээр багц цагийн сургалтанд хамруулан, биелэлтэнд нь анхааран ажиллаж байна. Шаардлагатай тохиолдлуудад эмнэлзүйн сургалтыг сургагч багш нар авч ажил дээрээ сургалт явуулдаг. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн HRDS программд эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг бүртгүүлэн, баталгаажуулж багц цагийн сургалтуудад хамруулан ажиллаж байна.<br><br>
2025 оны байдлаар төрөлжсөн мэргэжил эзэмшсэн эмч 3, сувилагч -7 суралцаж байна. Үндсэн мэргэшлийн сургалтад эмч -13 ажилтан суралцаж байна. Магистрын сургалтанд 2 эмч, 3 сувилагч суралцаж байна. Сувилагчийн ангид 11 хүн сурч байна. Эмчийн ангид 3 сувилагч суралцаж байна.<br>
2025 онд Эрүүл мэндийн Хөгжлийн төвөөс https://hr.hdc.gov.mn/ буюу HRDS программ дээр эмч, сувилагч, тусгай мэргэжилтний мэдээллийг оруулан ажиллаж байна. Уг программ дээр багц цагийн биелэлт, сургалтуудад хамрагдах боломжтой болсон.<br>
2025 он Хөгжлийн төв, Нийслэлийн эрүүл мэндийн газар, "Сүхбаатар" Нэгдсэн эмнэлэгтэй хамтран төрийн сангийн зардлаар 4 ажилтан сургалтад хамрагдан суралцаж байна.
</td></tr>
<tr><td></td><td></td><td>Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2021 оны шинэчилсэн мэдүүлгийг бүртгэх тайланг нэгтгэх</td><td>Мэдүүлгийг бүртгэл, тайланг АТГ-д хүргүүлэх</td><td>ОНӨАТГазар тул мэдүүлэг өгдөггүй болно.</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Авлигын эсрэг хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, дүрст сурталчилгаа хийх | Үйл ажиллагаанд ашиглагдах боломжоор хангах | • “Талархал цуглуулцгаая!” идэвхжүүлэлтийн ажлыг зохион байгуулснаар тасаг бүрд “Сэтгэлийн илгээмж” буланг давхар бүрд нээн ажиллуулж “Талархлын хайрцаг”, Санал хүсэлтийн дэвтрийг үйлчлүүлэгчдийн өрөөгөөр аялуулж байна.<br><br><br><br><br>• Тасаг бүр Авлигын эсрэг хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас, дүрст сурталчилгааг ашиглан авлигын хор хөнөөлийг таниулан ажиллаж: байна. |
| 6 | Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуй нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа үйлчилгээний лавлагаа, мэдээллийг сайжруулах | Лавлагаа, мэдээлэл авах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх | Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа үйлчилгээний лавлагаа, мэдээллийг ашиглан ажилчдыг хувийн хэргийн бүрдүүлэлтийн баяжилтыг хийж байна.<br>• Эмч, сувилагчийн лицензийн баталгаажуулалт, шалгалтын дүн зэргийг Эрүүл мэндийн яам, хөгжлийн төвийн сайт хуудаснуудаас авч ажилдаа тусгаж байна. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтыг тогтолцоог боловсронгуй болгох | | | |
| Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгэг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | | | | |
| 7 | Төрийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулж буй худалдан авах үйл ажиллагааны 70 орчим хувийг цахим хэлбэрт шилжүүлэх | тусгай зөвшөөрөл олгох, тендерийн үйл ажиллагааг цахимаар үзүүлдэг болох | Манайд хамааралгүй байна. Төрийн болон олон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ явуулаагүй. |
| 8 | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээг бэхжүүлэх | Авлига албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн талаар мэдээлэл авах "Авлигагүй Улаанбаатар" байнгын утсыг ажиллуулах | Авлига ёс зүйн зөрчилтэй холбоотой мэдээлэл авах арга хэлбэр сайжруулах | • "Сүхбаатар" Нэгдсэн эмнэлэг нь үйлчлүүлэгчдээс санал, гомдол, хүсэлтийг хайрцгаар болон утсаар авч үнэлгээ санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. Мөн Засгийн газрын 11-11, 12-00 дугаартай утсанд "Сүхбаатар" Нэгдсэн эмнэлгийн нэр дээр талархал -23, санал хүсэлт- 6, гомдол-12 ирснийг холбогдох алба, тасаг, нэгжид дамжуулан хариуг нь цаг тухай бүрд нь өгч шийдвэрлэсэн болно.<br>• Ёс зүйн хорооны бүрэлдэхүүн үйл ажиллагаа, зөрчлийн мэдээ зэргийг Хаяг: info@sbne.ub.gov.mn цахим хуудас болон эмнэлгийн мэдээллийн самбарт байршуулж ажиллаж байна.<br>• Архивын эрхлэгч - Бичиг хэргийн ажилтан Сандуйжав овогтой Оюунтуяа нь байгууллагын ажилчид, харилцагч байгууллага, үйлчлүүлэгчдээс бичгээр санал хүсэлт, гомдол хүлээн аван ажиллаж байна. Ажлын бүх өдрүүдэд иргэдийг нээлттэй хүлээж авч, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзуулж, өргөдөл гомдлыг бичгээр болон амаар 350948, 350970 утсаар хүлээн авдаг. /Ажил үүргийн хуваарийг тодорхой ажлын байрны тодорхойлолтод зааж өгсөн/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | • Байгууллагын ажилчдын ажиллах цагийн хуваарь болон эмчийн тухай мэдээллийг хаалган дээр нь байрлуулан ажиллаж байна. Мөн тасаг бүр танилцуулгаа жил бүр шинэчлэн танилцуулах самбар гарган ажиллаж байна.<br>• Байгууллагын захиргаанд эмч, ажилчид, үйлчлүүлэгчдээс ирсэн санал, хүсэлт, өргөдлийг байгууллагын хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна.<br> |
| 9 | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын мэдээллийг нээлттэй байлгах, цахим хуудсыг шинэчлэн өргөжүүлэлт шинэчлэлтийг хийх | Иргэдийн үнэн зөв, бодит мэдээлэл авах боломж, нөхцөл нэмэгдүүлэх | www. info@sbne.ub.gov.mn цахим хаяг дээр тухайн цаг үеийн мэдээлэл болон нээлттэй ажлын байрны зар, эрүүл мэндийн зөвлөгөө, санхүүгийн тайлан тооцоо, манай эмнэлгийн түүхэн замнал, бүтэц зохион байгуулалт, тасгуудын танилцуулга, статистик мэдээллүүд, ажилчдын судалгаа, хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөө зэрэг багтаж байна.<br>• Эмнэлгийн мэдээллийн ил тод байдлыг үйл ажиллагааны танилцуулга, хүний нөөц, төсөв санхүү, ёс зүй, мэдээлэл, хууль эрх зүй, тайлан төлөвлөгөө, өргөдөл гомдлыг мэдээллийн самбарт байршуулав.<br>• Хэвтэн эмчлүүлэх журам, эмнэлэгт хэвтүүлэх журам зэрэг өвчтөнд шаардлагатай мэдээллийг самбарт танилцуулж, хүлээн авах тасагт байрлуулсан.<br>• Нийт тасаг нэгжүүд хаягуудыг шинэчилсэн. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | |   |
| 13 | | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад тодоот, аудит, санхүүгийн хяналт шалгалтын хийх, зөрчлийг илрүүлэх, хариуцлага хүлээлгэх | Эрсдtлийн удирдлага, хяналтын тогтолцоо бий болсон байна. | • Нийслэлийн аудитын газраар жил бүр аудитын хяналт хийлгэж, ажиллаж байгаа бөгөөд ямар нэгэн акт, зөрчилгүй ажиллаж байна.<br>• СБНЭ-ийн хэмжээнд эрсдэлийн баг үйл ажиллагаа явуулж байна. |
| Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 3 дугаар зорилтын хүрээнд: Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх | | | | |
| 14 | Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй хариуцлагатай | Гадаадын зээл тусламж орон нутгийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх | Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нээлттэй болж, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна. | • Байхгүй болно. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | байх зарчмыг мөрдүүлэх | Гадаадын зээл тусламж орон нутгийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээний явц, гүйцэтгэлийг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх | Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явц нээлттэй болж, гүйцэтгэлд тавих хяналт сайжирсан байна. | Байхгүй болно. |
| 16 | | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага, судлаач, үнэлгээчнээр үнэлгээ хийлгэх | Төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн нээлттэй болж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх | Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай холбоотой 24 төрлийн тайланг жилийн эцсээр Нийслэлийн Эрүүл мэндийн газар хүргэгддэг ба үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнгийн эргэн хяналт шинжилгээг ЭМЯ, НЭМГ-аас ирж хийдэг. |
| Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 7 дугаар зорилтын хүрээнд: Авлигаас сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих | | | | |
| 18 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, | Олон нийтийн дэд зөвлөлтэй хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулах, нээлттэй хаалганы өдөрлөгийг хамтран зохион байгуулах, олон нийтийн зөвлөлөөс өгсөн | Төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн нээлттэй болж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх Авлигын эсрэг хууль | • Байгууллагын өөрийн нөөц бололцоо болон дотоодын сургалтад явуулсан байдал: |

| № | *Сургалтын чиглэл* | *Явуулсан удаа* | *Суусан хүний тоо* | *Зарцуулсан мөнгөн дүн /₮/* |
|---|---|---|---|---|
| **I.** | **Байгууллагын сургалт** | | | |
| 1. | Ёс зүйн сургалт | 98 удаа | 2899 | 17’527’000.0 |
| 2. | Харилцаа хандлагын сургалт | 90 удаа | 2809 | |
| 3. | Хууль эрх зүйн сургалт | 95 удаа | 3220 | |
| 4. | “Би байгууллагынхаа нэгэн хэсэг” байгууллагын соёл, | 2 удаа | 107 | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | үйлчилгээг сайжруулах | зөвлөмжийг хэрэгжүүлэх | тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжруулах Авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг нэмэгдүүлэх | (see below) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | харилцаа хандлага, багаар ажиллах ур чадварын сургалт /байгуул/ | | | |
| 5. | “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй” | 50 удаа | 3844 | |
| 6. | Эрүүл аж төрөх | 85 удаа | 2567 | |
| 7. | Тусламж үйлчилгээ | 150 удаа | 4191 | |
| 8. | Халдвар сэргийлэлт | 140 удаа | 5195 | |
| 9. | Бусад | 63 удаа | 2716 | |
| II. | Дотоодын сургалт | | | |
| 6. | Бусад зохион байгуулалт, төлөвлөлтийн сургалтад | 59 | 151 | 72’937’490.47 |
| 7. | Ур чадварыг нэмэгдүүлэх чадавхын сургалт | 51 | 654 | |

- Ёс зүйн талаар 2025 онд нийт 54 удаа давхардсан тоогоор 1504 хүнд сургалт зохион явуулсан байна.
- Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй харьцаа хандалга, хуулийн мэдлэгийг сайжруулж, тэдний манлайлах үүргийг нэмэгдүүлэх зорилгоор Хүний нөөцийн албанаас “БИ БАЙГУУЛЛАГЫНХАА НЭГЭН ХЭСЭГ” сургалтыг 1 удаа зохион явуулж, 55 эмч, сувилагч, асрагч, шинэ ажилтан нарыг хамруулсан. Сургалтад:
  - ❖ Би хаана явна вэ
  - ❖ Хувь хүний хөгжил
  - ❖ Цагийн менежмент
  - ❖ Баг дотор би хэн бэ, багт гүйцэтгэх миний үүрэг

Хамтран ажиллахын утга учир зэрэг сэдвүүдийг багтаан хөгжөөнт тоглоом тоглуулж нэг өдрийг идэвхтэй өнгөрүүлсэн болно.






| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | • СБНЭ-ийн даргын 2018.11.30-ны өдрийн А/181 дугаар тушаалаар "Авлигын эсрэг олон улсын өдрийг" 2025 оны 12 сарын 09-нд тэмдэглэхээр төлөвлөн ажиллаж байна. |
| 19 | | Ил тод Улаанбаатар Академи-Зөвлөлдөх ардчиллын танхим"-ын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах зорилгоор "Хүнд сурталтай төрийн үйлчилгээ-түүнээс урьдчилан сэргийлэх арга зүй" сэдэвт хэлэлцүүлгийг нийслэл, дүүргийн Иргэний танхимтай хамтран зохион байгуулах, үр дүн, зөвлөмжийг төрийн байгууллагуудад хүргүүлэх сурталчлах | | • Авлигын хор хөнөл аюулыг ухуулан ажиллаж байна. Сургалтын эмч 2025 оны сургалтын төлөвлөгөөндөө авлигын эсрэг сургалтыг төлөвлөн тасралтгүй зохион явуулж байна.<br>• Хууль эрх зүйн боловсрол ажилчдад олгох үүднээс 8 удаа 574 хүнд сургалт зохион явуулсан.<br>• Ажилчдын авлигын эсрэг хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, авлигын нийгмийн хор аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зохих мэдлэг эзэмшүүлж, түүнийг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэхэд зорилгоор "Эмнэлгийн ажилтны зөрэг хандлагыг төлөвшүүлэх, үйлчилгээний соёл сайжруулах" үүднээс системтэйгээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулж эмнэлэг дотор зурагт хуудас танилцуулга наасан.<br>• Олон улсын эмч нарын өдөр, олон улсын сувилагчийн өдрийг тохиолдуулан нийт эмч, сувилагч нарын үүргийг ухамсарлуулах, хариуцлагыг өндөржүүлэх үүднээс тангараг өргөх уламжлалт ёслол зохион явуулдаг уламжлал тогтсон ба хариуцлагын тогтолцоог баримтлахад чиглүүлэн ажиллаж байна.<br>• Эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд багш шавийн гэрээ байгуулан хамтран ажилласнаар мэдлэг, туршлагаа солилцон эмчилгээ үйлчилгээний чанар сайжрах алхам боллоо.<br>  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 21 | | Гадаадын орны болон ижил чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага солилцох | Хамтын ажиллагааг өргөжүүлэх | ОХУ-ын Н.А.Семашкогийн нэрэмжит эмнэлэг, БНХАУ-ын Хөх хот хотын 1-р төв эмнэлэгтэй хамтран ажиллаж байна. Бид улс орны тэргүүн туршлагуудыг хуваалцаж, сургалт зохион явуулах, ажилтан бэлдэх тал дээр хамтран ажиллаж байна.<br>• БНХАУ-ын ӨМӨЗО-ны Анагаахын Сургуулийн харьяа 2-р эмнэлэгт IV/20-VIII/20 хүртэлх хугацаанд Мэс засал гэмтлийн тасгийн их эмч Д.Отгонсүрэн гэмтлийн үений мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байна. |

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ,
ГАДААД ХАРИЛЦААНЫ АЛБАНЫ ДАРГА Д.ЭНХЭЭ

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:
ЗАХИРАЛ Б.БАТЧИМЭГ